

**УДАМ ДАМЖСАН НЭРТ ЭРДЭМТЭД**

Э.Пүрэвжав  
/ШУА/

Монгол улсын Төрийн шагналтан, Монгол улсын Шинжлэх ухааны академийн анхны жинхэнэ гишүүн (академич), үндэсний монгол хэл шинжлэлийн шинжлэх ухааны ууган доктор (Sc.D), профессор, гарамгай дуун хөрвүүлэгч, эрдэмтэн зохиолч Ёншөөбү овогт Бямбын РИНЧЕН (1905-1977) бол эх орондоо үндэсний монгол судлалыг үүсгэн хөгжүүлж, монгол туургатны хэл бичиг, утга соёлын өв уламжлалыг дэлхий дахинаа таниулан сурталчлахад үлэмжийн хүндтэй гавьяа байгуулсан монголын агуу их бичгийн мэргэдийн нэг мөн билээ.

Профессор Б.Ринчен монгол хэл шинжлэл, монгол хэл бичгийн ухаан, монгол нэр томъёо судлал, монгол ардын аман зохиол судлал, монгол угсаатны зүй, монгол бөө мөргөл судлал, монгол шашин судлал, монгол утга зохиол судлал, эх түүх судлал, урлаг судлал, утга соёлын өв судлал, монгол ардын зан заншил судлал, монгол түүхэн сурвалж судлал тэргүүтэн монгол судлалын бараг л бүх салбараар эрдэм шинжилгээний өгүүлэл, тэмдэглэл, нийтлэл, товхимол, эмхэтгэл, дээж бичиг, ном, судалгааны ганц сэдэвт бүтээл туурвиж хэвлүүлсэн нь шинжлэх ухааны нарийн үндэслэлтэй, эрдэмтэн хүний холч хараа, гярхай ажиглалт, нягт дүгнэлттэй байдаг учраас уншиж танилцсан хэн хүний анхаарал сонирхлыг ямагт татаж чаддагаараа нэн өвөрмөц онцлогтой.



Бямбын РИНЧЕН (1905-1977)

Академич Б.Ринчен монгол судлалд үнэт хувь нэмрээ оруулж чадсан “Монгол бичгийн хэлний зүй” (1964-1967) хэмээх дөрвөн боть суурь судалгааны бүтээл, “Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл” (1968), “Монгол ард улсын хамниган аялгуу” (1969), “Монгол ард улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас” (1979) зэрэг бүтээлийг Улаанбаатар хотноо хэвлүүлж, монгол ардын аман зохиол, аман билиг судлалаар “Folklore Mongol” (1960-1972) хэмээх таван боть судалгааны цуврал бүтээл, монгол бөө мөргөл судлалаар “Les Matériaux pour L'étude du Chamanisme Mongol” (1959-1975) хэмээх гурван боть тэргүүтэн эрдэм шинжилгээний бүтээлийг ХБНГУ-д нийтлүүлж хэвлүүлсэн юм. Эдгээр ном бол эдүгээгийн монгол судлалд тэр болгон дахин давтагдашгүй хосгүй ховор бүтээл туурвил гэж дотоод, гадаадын монголч эрдэмтэд зүй ёсоор үнэлэн цэгнэдгийг онцлон дурдалтай.

Их эрдэмтэн, академич Б.Ринчен монгол судлалын чиглэлээр хэдэн зуун бүтээлийг монгол, орос, англи, франц, герман, польш, унгар, чех хэлээр бичиж нийтлүүлжээ. Гадаадын сэтгүүл, цувралд хэвлүүлсэн судалгааны өгүүлэл, эрдэм шинжилгээний бүтээлүүд нь эдүгээ

*“Эрээд эрээд олдошгүй эрдэнэ  
Сураад сураад олдошгүй сувд”*

лугаа адил олдохуйяа ховор эрдэнэ болжээ. Түүний туурвиж хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны бүтээлийн бүрэн түүвэр нь хэвлэгдэж хараахан гараагүй байгаа. Эрдэмтэн зохиолч Б.Ринчен 1927 оноос 1977 он хүртэл хагас зуун жил Монгол улсын Судар бичгийн хүрээлэн, Шинжлэх ухааны хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнд тасралтгүй үр бүтээлтэй ажилласан манай хүрээлэнгийн ахмад судлаач болно. Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн үүсэн байгуулагдсаны 90 жил, Монгол улсын Шинжлэх ухааны академи болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн байгуулагдсаны 50 жилийн тэгш дүүрэн их ойг тохиолдуулан, академич Б.Ринчен докторын монгол судлалын чиглэлээр туурвиж нийтлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээл туурвилыг нь “Бямбын РИНЧЕН. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*” гэсэн ерөнхий нэрээр 2011 онд анх удаа ботилон хэвлүүлэх их ажлыг эхэлж, “Монгол хэл бичгийн ухаан” (I), “Монгол утга зохиол судлал” (II), “Mongol Studies” (III), “Монголоведение” (IV) хэмээсэн дөрвөн боть, 2012 онд “Монгол бичгийн хэлний зүй”, тэргүүн дэвтэр [удиртгал] (V), “Монгол бичгийн хэлний зүй”, дэд дэвтэр [авиан зүй] (VI), “Монгол бичгийн хэлний зүй”, гутгаар дэвтэр [хэлбэр судлал] (VII), “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр [өгүүлбэр зүй] (VIII) гэсэн бүтээлийг өргөн олны хүртээл болгосон билээ. “Бямбын РИНЧЕН. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*” цувралын есдүгээр ботид академич Б.Ринчен докторын бичиж нийтлүүлсэн монгол ардын аман билиг судлалын чиглэлээрх эрдэм шинжилгээний бүтээлүүдийг нь эмхэтгэн “Монгол аман билиг судлал” гэсэн нэрээр гаргахаар бэлдэж байна.

Академич Бямбын Ринчен багштаны бичиж туурвисан эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн секторын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, хэл бичгийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Э.Пүрэвжав 1989 онд “Монгол судлалын мэдээлэл” сэтгүүлийн № 2 (4)-ын 79-90 дүгээр тал [228 бүтээл], 1997 онд “Э.Пүрэвжав. Монгол хэл бичиг судлал” цувралын нэгдүгээр дэвтрийн 115-133 дугаар тал [477 бүтээл], 2000 онд “Л.Болд. Монгол хэл шинжлэлийн түүхэн найруулал” номын нэгдүгээр дэвтрийн 159-176 дугаар тал [477 бүтээл], 2003 онд “Ц.Шагдарсүрэн,

О.Адъяа. Бямбын Ринчен” (“Монгол улсын шинжлэх ухаан” 108 боть цувралын V боть) хэмээх номын 99-132 дугаар тал [667 бүтээл], 2005 онд “МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг “Acta Mongolica”, Volume 5 (246)” сэтгүүлийн 21-38 дугаар тал [714 бүтээл], 2005 онд “Э.Пүрэвжав. Их эрдэмтэн, академич Б.Ринчен” судалгааны бүтээлийн 99-135 дугаар тал [715 бүтээл], 2011 онд “Бямбын Ринчен. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган”, I боть (монгол хэл бичгийн ухаан)” эмхэтгэлийн 7-28 дугаар тал [900 бүтээл], 2015 онд “Монгол хэл бичиг, өв соёлын тулгамдсан асуудал - III” (академич Б.Ринчений мэндэлсний 110 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал) эмхэтгэлийн 97-131 талд [900 бүтээл] нэмэн дэлгэрүүлж, нийтдээ найман удаа хэвлэн нийтлүүлсэн болно.

Профессор Б.Ринчен монгол судлалын олон салбарыг дэлхий дахинаа хөгжүүлэн бэхжүүлэхэд өөрийн бүтээлч хувь нэмрээ оруулсан бөгөөд түүний нэн идэвхтэй зүтгэл санаачилгаар 1950 хэдэн оны сүүлээс “Монголын судлал”, “Хэл зохиол судлал”, “Аман зохиол судлал”, “Дурсгалт бичгийн чуулган” зэрэг цуврал бичиг тогтмол хэвлэгдэх болсон бөгөөд эдүгээ ОУМСХ-ны эрхлэн гаргадаг “Монголын судлал” цуврал нь 45 дугаар, ШУА-ийн Хэл зохиолн хүрээлэнгийн эрхлэн гаргадаг “Хэл зохиол судлал” цуврал 37 дугаар, “Аман зохиол судлал” цуврал 34 дугаар, “Дурсгалт бичгийн чуулган” цуврал нь 28 дугаар хэвлэгдэн гараад байна.

Академич Б.Ринчен Монгол орны гадаад харилцаа харьцангуй хязгаарлагдмал хэцүү байсан (1959) тэр үед академич Цэндийн Дамдинсүрэн (1908-1986), Шадавын Лувсанвандан (1910-1983), Амгаагийн Лувсандэндэв (1927-1997) нартай хамтран Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлыг анхлан санаачилж, эх орондоо амжилттай зохион байгуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэхүү их хурал нь дэлхийн олон орны монголч эрдэмтний байнгын хамтын ажиллагаа, хүчин зүтгэлийг нэгтгэн өгч, олон улсын монголын судлалд нэгэн шинэ үе шатыг нээснээрээ түүхэн ач холбогдолтой билээ.

Монгол хэл бичгийн судлал, монгол ардын аман билиг судлал, монгол угсаатны зүй, монгол сурвалж судлал, монгол утга соёлын өв судлал, монгол бөө мөргөл судлал, монгол орчуулгын онол, намтар судлал тэргүүтэн олон төрлийн нарийн судалгаа шинжилгээ, ажил мэргэжлийг нэгэн биеэр тэгш эзэмшин, туурвиж бүтээхийн ид хав, эгэлгүй эрхэмсэг үлгэр жишээг биеэрээ үлгэрлэн үзүүлсэн Монгол улсын Төрийн шагналтан, эрдэмтэн зохиолч, академич, профессор Эншөөбү овогт Бямбын РИНЧЕН доктор (Sc.D) нь халуун эх оронч, ард түмэндээ чин үнэнч, гуйвшгүй цэх шударга, улс монголоо гэсэн сонин содон чанараараа монгол туургатны хүндэтгэл бишрэлийг татсан, үнэхээрийн билиг танхай, их бичгийн хүмүүн байсан юм. Их эрдэмтэн, академич Эншөөбү овогт Б.Ринчен багштан бол эх орондоо төдийгүй дэлхий дахинаа монгол судлалыг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд үлэмжийн их гавьяа байгуулсан [Пүрэвжав, 2005, 84], үеийн үед дуурсагдах агуу их эрдэмтэн мөнөөсөө мөн.

Их эрдэмтэн, академич Б.Ринчен профессорын эрдэм шинжилгээний олон талт бүтээл туурвил нь зөвхөн монголын судлал төдийгүй, алтай судлалын цар хүрээ, төв Азийн олон ард түмний утга соёлын харилцааны түүхнээ онцгой ач холбогдолтой байсныг дотоод гадаадын эрдэмтэд олонтоо тэмдэглэсэн нь буй. Дэлхийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан бодит гавьяа зүтгэлийг нь зүй ёсоор үнэлж, 1958 онд Олон улсын Фин-угорын нийгэмлэгийн хүндэт профессор, 1965 онд Олон улсын Алтай судлалын байнгын Бага хурлын алтан медаль, 1970 онд БНУАУ-ын ШУА-ийн хүндэт гишүүн, 1970 онд Польшийн зохиолчдын

нөхөрлөлийн мөнгөн медалиар урамшуулан шагнаж байсан нь түүнийг дэлхийн соёлт хүмүүн төрөлхтөн бодитоор үнэлж байсны илрэл мөн.



Будын РАДНААЖАВ (1874-1921)

Түүний өвөг эцгийн нэрийг Бямбын Буд (1842-1913) гэдэг байсан аж. Түшээт хан аймгийн Буурын голд төрж өссөн, хөх нохой жилтэй Б.Раднаажав (1874-1921) нь Хиагтын хэлмэрчийн сургуульд нэг хэсэг суралцаж байгаад, Богдын хүрээ орж “хичээнгүй сайд” гэж олноо алдаршсан Б.Цэрэндорж (1867-1928) багшаар манж хэл, хятад хэл бичиг заалган, Их хүрээнээ суудаг оросын консул Я.П.Шишмарев (1833-1915)-ын тусламжаар Бээжин хот орж хятад, манж хэл бичгийг тусгайлан оролдож, Хиагтын хязгаарын комиссарын яаманд манж, монгол, хятад хэлний орчуулагч, комиссарын албыг 1899-1915 онд хашиж, Монгол, Орос, Хятад гурван улсын гэрээнд хэлмэрчлэн оролцож, онцгой идэвх зүтгэл гаргасны төлөө “Эрдэнийн очир” одонгоор шагнуулж байсан удаатай.

Хятад хэлний дээд зэрэглэлийн орчуулагч (старший классный переводчик китайского языка) Б.Раднаажав нь буриад, орос хэлнээс гадна монгол, манж, хятад, англи, герман хэлийг зохих хэмжээнд гарамгай эзэмшсэн [Чимитдоржиев, 2004, 111] хэл бичиг судлаач байжээ. Хуучин монгол бичгийн хэл судлаач, монгол хэлний хэл зүй судлаач, монгол орос хоёр хэлний таван толь бичиг туурвин гаргаснаараа олонд алдаршсан юм.

Өргөн хэрэглээний 1600 гаруй толгой үгийг багтаасан “Халх аялгууны орос монгол орчуулагч” гэсэн толийг 1910 онд Троицкосавск хотод хэвлүүлсэн нь тухайн үеийн түүхийн сурвалж, засаг захиргааны тухай үндсэн мэдээллийг агуулснаараа өвөрмөц онцлогтой. Энэхүү толь бичгийг тэр үеийн Монголд ажиллаж байсан оросын худалдаачид, хээрийн шинжилгээний ангийнхан өргөн ашигладаг байжээ.

Нэрт толь зүйч Б.Раднаажав 1913 онд 10000 гаруй толгой үгтэй “Халх аялгууны ярианы хэлний орос монгол толь бичиг”-ийг цөөн хувиар хэвлүүлсэн байна. Уул толь бичиг хэвлэгдэж олны хүртээл болсноос хойш эдүгээ яг 100 жил болжээ. Энэхүү толь бичиг зохиогчийн өмнөх үгэнд монгол хэлний хэл зүйн асуудалд онцгой анхаарлаа хандуулж, үгийн өргөлт, нэр үгийн тоо, хүйс, нэр

үгийн хувилал<sup>1</sup>, төлөөний нэр, үйл үгийн хувилал, хэв, тооны нэр, үгүйсгэх сул үг тэргүүтний талаар товч тодорхой тайлбарласан байна. Тэрбээр “Монгол бичгийн хэл нь ярианы хэлнээсээ нэлээн ялгаатай болж, бичиг үсэг мэдэхгүй монголчууд нь уншиж ойлгоход түвэгтэй болсон. Монголчууд “о” авиаг хоёр янзаар дууддаг. Орос хэлний “слово” хэмээх үгэн дэх “о”-той адил дуудна. Жишээ нь: “Олон” (много) гэсэн үгийн авиа нь “о”, “у”-гийн дундуур холилдсон маягтай дуудагдана. Тухайлбал: “осо” (вода) нь “усо” биш юм. “Соргоули” (училище) гэдэг нь “соргули” биш болно” [Раднаажав, 1913, II] хэмээсэн дүгнэлт гаргасан нь нэн сонирхолтой байна. Б.Раднаажав монгол бичгийн хэлний үгийн бүрэлдэхүүнийг кирил үсэгт хөрвүүлэн буулгах анхны оролдлогыг тодорхой хэмжээнд тогтолцоотой хийж, зохиож хэвлүүлсэн “Халх аялгууны ярианы хэлний орос монгол толь бичиг” бол монгол хэлний түүхэн хөгжил, нэн ялангуяа үгийн сангийн үндсэн бүрэлдэхүүний төлөв байдлыг танин мэдэхэд хэрэглээний ач холбогдолтой толь бичиг мөн гэж үзэж байна. Энэ толь бичгийн “А” толгойт үгээс цөөн хэдэн жишээ дурдсу:

*Абазурь* гырэбчи, сарабчи, хухурь (гэрэвч, саравч, хөхүүр)

*Авангардь* габшигай цэригь (гавшгай цэрэг)

*Аграномія* таряный соргоули (тарианы сургууль)

*Азартная игра* муруйтуй тоглонь (мөрийтэй тоглоом)

*Актерь* си долдагь хунь (ший дулдаг хүн)

*Алмазь* дорчжипалма (доржпалам)

*Амбарь* юмь хоряхо байшинь (юм хураах байшин)

*Анархисть* орбасань хунь (урвасан хүн)

*Анекдоть* аля үгэ (алиа үг)

*Аптека* эмьй пуцзэ (эмийн пүүс)

*Аристократія* сорбальчжитань (сурвалжтан)

*Ариөметика* цзорхай (зурхай)

*Артиллерія* ухырь боу (үхэр буу)

*Архивь* дансо хоряхо гырь (данс хураах гэр)

*Атамань* туру, дарго, атамань (төр, дарга, атаман)

*Аукционь* доудачжи ходалдахо (дуудаж худалдах).

Еншөөбү овогт Б.Раднаажав 1913 онд хэвлэн нийтлүүлсэн “Халх аялгууны ярианы хэлний орос монгол толь бичиг”-ийнхээ хавсралт болгон 1912 оны X сарын 21-ний өдөр Өргөө хотод гарын үсэг зурж баталгаажуулсан Орос, Монгол улсын хоорондын гэрээ зөвшилцөл, хурлын тэмдэглэлийг бүрэн эхээр оруулсан нь манай түүх, нийгэм судлаач нөхдөд чухал хэрэгтэй судлагдахуун болох нь дамжиггүй.

Тэрбээр 1914 онд монгол ярианы хэлний хамгийн өргөн хэрэглээний 4000 толгой үгийг багтаасан “Монгол бичгийн хэлээрх хадмал бүхий халх аялгууны орос монгол товч толь бичиг”-ийг Харбин хотноо нийтлүүлжээ. Энэ бүтээлдээ монгол бичгийн хэлний хэл зүйн зайлшгүй хэрэгцээтэй гол дүрмүүдийг тусган оруулснаараа онцлогтой юм.

Мөн 1915 онд 8000 толгой үг бүхий “Монгол орос толь бичиг” хэмээх бүтээлийг Иркутск хотноо хэвлүүлж, монгол хэлний хэл зүйн дүрэм, зөв бичих дүрмийг тухайлан тайлбарласан байна.

Монгол хэл бичиг судлаач Б.Раднаажавын ууган хөвгүүн Ринчений багынх нь нэрийг Ринчендорж гэдэг байжээ. “Ринчендорж” хэмээсэн нэрийг Хараагийн Дара эхийн хувилгаан лам хайрласан бөгөөд “өөрийн хийддээ лам болгоно” хэмээн айлдсанаар төвөд хэлний цагаан толгой, Итгэл тэргүүтнийг хар багаасаа заалгаж

<sup>1</sup> Монгол хэлийг үндсэн 9 тийн ялгалтай хэмээжээ.

байжээ. Тэрбээр Норов, Дамдинсүрэн гэдэг хоёр эрэгтэй дүүтэй, Эрдэнэ гэдэг охин дүүтэй [Чимитдоржиев, 2005, 5] эцэг эхээс дөрвүүлээ юм. Төрж өссөн “гэр бүл хуучны сэхээтэн албан хаагч бөгөөд бичиг соёлыг эрхэмлэн үздэг, орос хэлийг чадамгай эзэмшсэн, уламжлалт ардын билэг зүйг дээдлэн хүндэтгэдэг байсан нь балчир хүүд нөлөөлсөн” [Цэнд, 2001, 3] нь дамжиггүй билээ.

Академич Б.Ринчений ууган охин Р.Нямаа “Бид гоц авьяастан биш юм аа. Суут хүний дараа байгаль амардаг гэсэн үг бий. Гэвч бид муу улс болоогүй ээ. Аавынхаа өгсөн хүмүүжил, хатуужлын хүчинд бид дажгүй л сэхээтэн болсон. Бид аавынхаа мэргэжлийг өвлөөгүй ч монголоо гэсэн сэтгэл зүтгэлийг нь өвлөж авсан” [БНБР, 1990, 94] хэмээн дурсан бичсэн байдаг бол удаах охин Р.Индра нь “Яагаад аавынхаа мэргэжлийг өвлөж аваагүй юм бэ? гэж биднээс хүн их асуудаг. Үнэндээ гэхэд монгол хэл гэдэг чинь улс төр юм байна гэж ойлгосон. Аав шиг хүн энэ мэргэжлээс болж ингэж зовж байхад бид бол давахгүй гэж бодсон. Тэгээд Ринчений удмыг авч үлдье гэвэл монгол хэл гэдгээс холхон байа гэж шийдсэн юм даа. Аав ч биднийг заавал монгол хэлний мэргэжилтэн болгох гэж зүтгээгүй” [БНБР, 1990, 96] хэмээн хэлсэн байдгийг дурдахад илүүдэх юун.

Доктор, профессор, академич Еншөөбү овогт Бямбын Ринчений ууган охин Р.Нямаа (1923) нь Монгол улсын хүний гавьяат эмч (1983), Анагаах ухааны дээд сургуулийн профессор, нүдний нарийн мэргэшлийн эмчээр олон жил дагнан ажиллаж, “Нүдний өвчин” сурах бичиг, “Нүд эмчлэх арга” зэрэг бүтээл хэвлүүлжээ.

Дунд охин Р.Индра (1928) нь мал зүйч мэргэшилтэй, Монгол улсын гавьяат багш (2007), хөдөө аж ахуйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, монгол цагаан идээ болон хавтгай тэмээ судлаач бөгөөд “Монгол орноо хөдөө аж ахуйг хөгжүүлэх байгалийн нөхцөл” (1974), “Молочная продуктивность, состав и свойства молока различных видов сельскохозяйственных животных, разводимых в МНР” (1983), “Сүү, сүүн бүтээгдэхүүн” (1984), “Тэмээний амьдын жин тодорхойлох арга” (1993), “Хавтгайн байршил, тархалт” (1999), “Монголд хавтгайн хорогдлын шалтгаан” (2000), “Монгол тэмээ” (2003) тэргүүтэн эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлсэн байна.

Бага охин Р.Шанзаа (1933-1999) нь ЗХУ-д дээд сургууль төгссөнийхөө дараа Мажар улс дахь Монгол улсын элчин сайдын яаманд орчуулагчаар ажиллаж байв.

Хүү Р.Барсболд (1935) нь палеонтологийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Монгол улсын ШУА-ийн академич (1991), АНУ-ын Нью-Йоркийн академийн жинхэнэ гишүүн, ОХУ-ын Хүндэтгэлийн одон (2013) хүртжээ. Академич Р.Барсболд бол Монголын болон Төв Азийн үлэг гүрвэлүүдийн судалгаагаар газрын цээжинд өнгөлөн торойн гарсан их эрдэмтний нэг мөн бөгөөд “Биостратиграфия и пресноводные моллюски верхнего мела Гобийской части МНР” (1972), “A New Dinosaur, Gallimimusbullatusn. gen., n. sp. (Ornithomimidae) from the Upper Cretaceous of Mongolia” (1972), “Хищные Динозавры Мела Монголии” (1983), “The Dinosauria” (1990), “Encyclopedia of Dinosaurs” (1997), “Fighting Dinosaurs: They really fought - First Intern. Meeting on Dinosaur Paleobiology, Museum Nacional de Historia Natural” (1998), “The skull of Velociraptor (Theropoda) from the Late Cretaceous of Mongolia” (1999), “The Age of Dinosaurs in Russia and Mongolia” (2000), “Non-marine Lower Cretaceous of Mongolia and Necessity of Dinosaur Hunting” (2007), “History of Oviraptors: From an Egg-thief to Big Mama and the Flightless Bird” (2009), “Эртний үлэг гүрвэлүүд. Палеонтологи” (2011), “Палеонтологи. Монгол орны эртний ургамал амьтны ангилал, морфологи, таксономи, нас, тархалт” (2011) тэргүүтэн судалгааны бүтээл туурвижээ.



Ринчений БАРСБОЛД

Еншөөбү овогт Ринчений Барсболд 1935 онд Улаанбаатар хотод төрж, 1959 онд ЗХУ-ын Москва хотын Геологи, хайгуулын дээд сургуулийг төгсчээ. Тэрбээр 1969 онд Ленинград хотноо “БНМАУ-ын говийн нутаг дэвсгэрээр тархсан дээд цэрдийн хурдсын давхарга зүй болон зөөлөн биетэн” сэдвээр дэд эрдэмтний зэрэг, 1979 онд Улаанбаатар хотноо “Монгол орны цэрд галавын махан идэшт үлэг гүрвэлүүд” сэдвээр палеонтологийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ.

Палеонтологийн шинжлэх ухааны доктор Р.Барсболд 1959-1961 онд Геологи, шинжилгээний удирдах газрын алтны хайгуул, зураглалын ангийн инженерээр хөдөлмөрийн их гараагаа эхэлж, 1961 онд МУИС-ийн геологийн тэнхимийн эрхлэгчээр томилогдож, 1965-1966 онд ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Палеонтологийн тасгийн эрдэм шинжилгээний ажилтан, 1967-1988 онд ШУА-ийн Геологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, 1988-1997 онд Геологийн хүрээлэнгийн захирал, 1997 оноос ШУА-ийн Палеонтологийн төвийн захирлаар үр бүтээлтэй ажиллаж байна. Тэрбээр 1993 оноос Монгол-Оросын найрамдлын нийгэмлэг, 1994 оноос Дэлхийн үлэг гүрвэл судлаачдын нийгэмлэгийн гишүүнээр сонгогдон идэвхтэй ажиллаж байгаа билээ.

Профессор Р.Барсболдын хөдөлмөр зүтгэлийг төр засгаас өндрөөр үнэлж, 1971 онд Хөдөлмөрийн хүндэт медаль, 1991 онд ШУА-ийн жинхэнэ гишүүн (академич), 1997 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, 2002 онд Засгийн газрын хүндэт өргөмжлөл, 2005 оны VI сард Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээжээ. Монголын болон Төв Азийн үлэг гүрвэлийн судалгаанд академич Р.Барсболд докторын оруулсан хувь нэмрийг үнэлж, АНУ-д төвтэй олон улсын сээр нуруутны палеонтологийн нийгэмлэгээс мэргэжлийн дээд шагнал А.Ромер-Ж.Симпсоны нэрэмжит медалиар шагнажээ.

Монголын шинжлэх ухааны хөгжил дэвшилд академич Р.Барсболдын оруулсан гол хувь нэмэр, нээлт гэвэл: Монголын махан идэшт үлэг гүрвэлийн бүтэц зүйн урьд нь шинжлэх ухаанд мэдэгдэж байгаагүй шинжүүдийг анхлан ялган тогтоож, тус аймгийн ангиллыг шинэчлэн тогтоож, дэлхийд тархсан анги бүлгүүдтэй нь жишиж, Монголын үлэг гүрвэлүүдийн эзэлж байсан байр суурь, түүхэн хөгжлийн

зүй тогтлыг улс орныхоо шинэ олдворуудын судалгаагаар батлан харуулсан [ШУА, 2011, 107] юм. Монголын махан идэшт үлэг гүрвэлүүдийн ангиллын жагсаалтыг ихээхэн өргөжүүлж, шинжлэх ухаанд 20 орчим шинэ нэгж төрөл, анги бүлгүүдийг санаачлан дэвшүүлж, Монголын олдворуудыг голлон түшиглэж, Умард Америк, Ази тивд тархалттай Oviraptorosauria, Ornithomimosauria гэж нэрлэсэн томоохон анги бүлгүүдийг нэгтгэн тогтоож, олон улсын ангиллын ерөнхий тогтолцоонд тусган оруулж чаджээ. Үлэг гүрвэлүүдийн улиран хувьслын зүй тогтол, тив хоорондын харилцаа холбоо, дэлхийн шинжлэх ухаанд дөнгөж л судлагдаж эхэлсэн төдий үлэг гүрвэлийн биологийн асуудлыг Монголын ховор олдворуудын үндсэн дээр судлан тайлбарлаж, үлэг гүрвэлүүдийн олдворын чулуужилтаар хадгалагдах боломжгүй зан үйлийн шинжүүдийг тодорхойлон босгох зам нээгдэж байгааг харуулж өгсөнд оршино.

Удам дамжсан нэрт эрдэмтэн, монгол хэл бичиг судлаач Еншөөбү овогт Б.Раднаажав (1874-1921), монгол хэл шинжлэлийн шинжлэх ухааны ууган доктор (Sc.D), профессор, гарамгай дуун хөрвүүлэгч, эрдэмтэн зохиолч, академич Б.Ринчен (1905-1977), палеонтологийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, академич Р.Барсболд (1935) нар болон тэдний үр хүүхдүүд нь эх орондоо үндэсний монгол судлалыг үүсгэн хөгжүүлж, монгол туургатны хэл бичиг, утга соёлын хосгүй нандин өв дурсгалыг дэлхий дахинаа таниулан сурталчлахад хүндтэй гавьяа байгуулсныг онцлон тэмдэглэе.

#### АШИГЛАСАН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. [БНБР, 1990] – Билгүүн номч Бямбын Ринчен (эмхэтгэж эрхэлсэн Г.Аким). -Уб., 1990. 238 х
2. [Пүрэвжав, 1997] – Э.Пүрэвжав. Монгол хэл бичгийн судлал (нэг) [редактор Х.Сампилдэндэв]. -Уб., 1997. 134 х
3. [Пүрэвжав, 2005] – Э.Пүрэвжав. Их эрдэмтэн, академич Бямбын Ринчен. -Уб., 2005. 152 х
4. [Пүрэвжав, 2005, а] – Э.Пүрэвжав. Монголын түүхэн сурвалж судлалд академич Б.Ринчений оруулсан хувь нэмэр. –“ШУА-ийн мэдээ” сэтгүүл, № 3 (177). -Уб., 2005. х.60-63
5. [Пүрэвжав, 2005, б] – Э.Пүрэвжав. Академич Б.Ринчений нэгэн захидал. –“Өнөөдөр” сонин, № 117 (2466). 2005.V.18
6. [Раднаажав, 1913] – Р.Бимбаевъ. Русско-Монгольский словарь разговорнаго языка на халхасскомъ наръчии. -Троицкосавскъ., 1913. XII + 424 + 05 стр
7. [Раднаажав, 1914] – Р.Бимбаевъ. Краткій Русско-Монгольскій словарь халхасскаго наръчия съ монгольской азбукой и необходимыми грамматическими правилами. -Харбинь., 1914. XXIII + 127 + III стр
8. [Цэнд, 2001] – Д.Цэнд. Бямбын Ринчен (намтар, уран бүтээл) [“XX зууны монгол зохиолчид” цувралын 66 дугаар дэвтэр]. -Уб., 2001. 47 х
9. [Чимитдоржиев, 2004] – Ш.Б.Чимитдоржиев. Кто мы – бурят-монголы. -Улан-Удэ., 2004. 129 стр
10. [Чимитдоржиев, 2005] – Ш.Б.Чимитдоржиев. Академик Бимбын Ринчен – выдающийся ученый и писатель (1905-1977). -Улан-Удэ., 2005. 96 стр
11. [ШУА, 2011] – Монгол улсын Шинжлэх ухааны академийн гишүүд (эмхэтгэсэн М.Чимэдлхам, Б.Амарзаяа, Ц.Энхжаргал). -Уб., 2011. 310 х